УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2026 оны 10 дугаар сар Улаанбаатар хот

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох дүн шинжилгээг хийх, хуулийн төслийн чанарыг сайжруулах, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 1.4 дэх заалтад заасан дараах 4 үе шатын дагуу хэрэгжүүлэв:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Уг хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалд тохируулан Аргачлалын 2.2, 2.9 дэх заалтыг үндэслэн дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо:

Зорилгод хүрэх байдал: Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох юм. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Улсын болон орон нутгийн нөөцийн удирдлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед нөөцийн бараа материалыг шуурхай гаргах зорилтыг хангаж буй эсэхийг тооцно.

Практикт хэрэгжих боломж: Шинээр нэмэгдэж буй чиг үүргүүдийг (тухайлбал, орон нутгийн нөөцийн бүрдүүлэлт, гэрээт хадгалагчийн хяналт шалгалт) хэрэгжүүлэх хүний нөөц, санхүүгийн бололцоо болон байгууллагын чадавхыг үнэлнэ.

Ойлгомжтой байдал: Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субьектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томьёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд[1] заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

"Орон нутгийн нөөц", "улсын нөөцийн агуулах", "улсын нөөцийн мэдээлэл" гэсэн шинээр нэмэгдэж буй ухагдахуунууд нь хууль хэрэглэгчдэд нэг мөр ойлгомжтой, логик дараалалтай томьёологдсон эсэхийг шалгана.

Харилцан уялдаа: Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субьектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай. Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг[2] хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгож байна.

Төслийн зүйл, заалтууд нь Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжтой зөрчилдөөнтэй эсэх, чиг үүргийн давхардал үүсгэж байгаа эсэхийг нягтлана.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Аргачлалын 3.1, 3.2, 3.3-т заасны дагуу хуулийн төслөөс шууд үр дагавар үүсгэж байгаа гол ач холбогдолтой зохицуулалтуудыг сонгон авч үнэлгээнд хамруулав:

- **Орон нутгийн нөөцийн эрх зүйн зохицуулалт:** Үзэл баримтлалд тусгагдсаны дагуу төсөлд "орон нутгийн нөөц"-ийн тодорхойлолтыг шинээр 3.1.10-д нэмж, орон нутгийн төсвөөр бүрдүүлэх, тайлагнах, хяналт тавих зохицуулалтын 13.1.11, 14.1.4, 16.1.1, 16.1.4, 16.1.5 дахь заалтууд төсөлд тусгагдсан.
- **Төр, хувийн хэвшлийн түншлэл ба агуулахын ашиглалт:** Агуулах барих, өргөтгөх ажлыг ТХХТ-ээр хэрэгжүүлэх, сул багтаамжийг түрээслэх, орлогыг төвлөрүүлэх зохицуулалт нь үзэл баримтлалд заасны дагуу хуулийн төслийн 7.4, 7.5, 7.6, 10.2 дахь хэсгүүдэд тусгасан.
- **Гамшгийн үеийн шуурхай удирдлага ба мэдээллийн сан:** Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр шуурхай бараа гаргах болон мэдээллийн санд бүртгэх зохицуулалтууд хуулийн төслийн 9.6, 9.7, 14.1.5, 15.1.5, 15.1.6-д тусгагдсан.
- **Гэрээт хадгалагч:** Төсөлд шинээр "17[1] дүгээр зүйл" буюу "Гэрээт хадгалагчийн үүрэг"-ийг оруулсан.

ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

---

[1] Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.
[2] Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

Аргачлалын 4.2 дахь хүснэгтэд заасан шалгах хэрэгслүүдийг ашиглан үр нөлөөг тооцлоо:

№	Шалгуур үзүүлэлт	Тохирох шалгах хэрэгсэл	Хэрэгжүүлсэн байдал ба үр дүн
1	**Зорилгод хүрэх байдал**	Зорилгод дүн шинжилгээ хийх	Онцгой нөхцөл байдлын үед нөөцийг шуурхай татах эрх зүйн гарц нээгдэж байгаа нь стратегийн зорилгод бүрэн нийцэж байна.
2	**Практикт хэрэгжих боломж**	Практикт турших / Санал авах	Орон нутгийн түвшинд нөөц бүрдүүлэх, мэдээллийг улирал тутам шинэчилж 5 өдрийн дотор бүртгүүлэх ажил нь орон нутгийн төсөв, хүний нөөцийн чадавхаас шалтгаалан зарим хүндрэл үүсгэх магадлалтай байна.
3	**Ойлгомжтой байдал**	Ойлгомжтой байдлыг шалгах	Шинээр орж буй “орон нутгийн нөөц”, “улсын нөөцийн агуулах”, “улсын нөөцийн мэдээлэл” гэсэн нэр томьёонууд тодорхой бөгөөд хуулийн хүрээнд логик дараалалтай байна.
4	**Харилцан уялдаа**	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Төрийн болон албаны нууцын тухай хуультай зөрчилгүй уялдсан боловч гамшгийн мэдээллийн сантай холбогдох мэдээлэл солилцох ажиллагааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай уялдуулах шаардлагатай.

3.1. Зорилгод хүрэх байдал:

Төслийн зохицуулалт нь хуулийн үзэл баримтлалд дэвшүүлсэн бодлогын зорилтуудыг бодитойгоор хангаж чадах эсэхэд дүн шинжилгээ хийхэд:

- **Орон нутгийн нөөцийн эрх зүйн зохицуулалт:** Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулах бие даасан орон нутгийн нөөцийн тогтолцоог бүрдүүлэх замаар орон нутгийн чадавхыг дээшлүүлэх зорилгод бүрэн хүрнэ.
- **Төр, хувийн хэвшлийн түншлэл ба агуулахын ашиглалт:** Агуулах барих, өргөтгөх ажлыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулиар шийдвэрлэх, сул байгаа багтаамжийг түрээслэх замаар төсөвт орлого

төвлөрүүлэх боломжийг бүрдүүлж, нөөцийн хадгалалтын инфраструктурыг сайжруулах зорилгоо хангана.

- **Гамшгийн үеийн шуурхай удирдлага ба мэдээллийн сан:** Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гамшгийн голомтод бараа материалыг цаг алдалгүй шуурхай гаргах, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх замаар хямралт нөхцөл дэх удирдлагын шуурхай байдлыг хангах зорилт биелнэ.
- **Гэрээт хадгалагч:** Хадгалагчийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, чанарын хяналт тавих тогтолцоог бүрдүүлснээр нөөцийн бэлэн байдал, найдвартай байдлыг хадгалах үндсэн зорилгод хүрнэ.

3.2. Практикт хэрэгжих боломж:

Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх этгээдүүдэд шаардагдах хүний нөөц, санхүүгийн бололцоо, байгууллагын чадавх байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхэд:

- **Орон нутгийн нөөцийн санхүүжилт ба тайлагнал:** Орон нутгийн төсвөөс нөөц бүрдүүлэх, мэдээллийг улирал тутам шинэчилж 5 өдрийн дотор мэдээллийн санд оруулах үүрэг нь зарим сум, дүүргийн төсвийн чадавх болон хүний нөөцийн бэлэн байдлаас шалтгаалан зарим хүндрэл үүсгэж болзошгүй тул орон нутгийн төсвийн төлөвлөлттэй уялдуулах шаардлагатай.
- **ТХХТ-ийн төслүүд болон түрээсийн удирдлага:** Агуулах барих өргөтгөх ажилд хувийн хэвшлийн оролцоог татах, багтаамжийг түрээслэх үйл ажиллагаа нь санхүүгийн бодит хэмнэлт авчрах боловч гэрээний хэрэгжилтэд хяналт тавих болон технологийн горимыг нарийн баримтлах шаардлагатай.
- **Шуурхай шийдвэр гаргалт ба тайлагнал:** Сайд болон Засгийн газрын түвшинд шийдвэр гаргаж бараа материалыг шуурхай татах үйл явц нь цаг хугацааны хувьд бодитой бөгөөд гамшгийн голомтод ажиллах нөхцөлийг бүрдүүлж өгснөөрөө практикт хэрэгжих өндөр боломжтой.
- **Гэрээт хадгалагчийн шалгуур:** Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн дагуу сонгогдох, аюулгүй байдлын шалгалтад хамрагдах шаардлага нь хадгалалтын аюулгүй байдлыг хангахад чухал боловч орон нутагт шалгуур хангасан хуулийн этгээд цөөрөх эрсдэлийг тооцох шаардлагатай.

3.3. Ойлгомжтой байдал:

Хуулийн төслийн зохицуулалт түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субьектүүдийн хувьд логик дараалалтай, тодорхой томьёологдсон эсэхэд дүн шинжилгээ хийхэд:

- **Нэр томьёо ба бүтэц:** Шинээр нэмэгдэж буй зохицуулалтууд (тухайлбал, орон нутгийн нөөцийн ойлголт, мэдээллийн сан, гэрээт хадгалагчийн үүрэг) нь тухайн салбарын хууль тогтоомжийн хүрээнд нэг мөр ойлгогдохуйц, логик дараалалтай байна.
- **Чиг үүргийн хуваарилалт:** Засгийн газар, Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон орон нутгийн Засаг дарга нарын хэрэгжүүлэх эрх хэмжээ, шийдвэр гаргах түвшин (9.6, 9.7, 14.1.4, 14.1.5) тодорхой бөгөөд

давхардалгүй томьёологдсон нь хэрэглэгчдэд ойлгомжтой байдлыг хангаж байна.

3.4. Харилцан уялдаа:

Төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцсэн, чиг үүргийн давхардалгүй эсэхэд дүн шинжилгээ хийхэд:

- **Хууль хоорондын уялдаа:** Гэрээт хадгалагчийг сонгохдоо Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтаар заасан нь худалдан авах ажиллагааны хууль тогтоомжтой бүрэн уялдсан. Түүнчлэн нууц мэдээлэлтэй харьцах ажилтанд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шаардлагыг тусгасан нь эрх зүйн зөрчилгүй байна.
- **ТХХТ ба төрийн өмчийн хуулиуд:** Агуулах барих өргөтгөхөд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, түрээсийн орлогыг төвлөрүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжийг эш татаж уялдааг хангасан.
- **Гамшгийн тухай хуультай нийцэх байдал:** Гамшгийн онцгой нөхцөл байдлын үед нөөцийн бараа материалыг шуурхай гаргах эрх зүйн зохицуулалт нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн зорилт, онцгой комиссын үйл ажиллагаатай хоорондоо нягт уялдаж, практик дээр тулгардаг хийдлийг зөв байдлаар нөхөж өгсөн байна.

ТАВ. ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийлээ. Үнэлгээнд хуулийн төсөл, үзэл баримтлалаас гадна холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд, хуулийн төсөлд ирүүлсэн санал зэрэг нэмэлт материалыг ашигласан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн аргачлалын тавдугаар бүлгийн дагуу үр дүнг баримтжуулж, дүгнэлт гарган зөвлөмж өгч байна:

Үр дүнгийн дүгнэлт

Хуулийн төсөл нь улсын болон орон нутгийн нөөцийн тогтолцоог бэхжүүлэх, хямралт нөхцөл дэх бараа материалын шуурхай удирдлагыг сайжруулахад чиглэгдсэн бөгөөд үзэл баримтлалын хувьд зорилгоо хангахуйц эерэг үр нөлөөтэй байна. Практикт хэрэгжих явцад зарим заалтыг журмаар нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Хуулийн төслийн хэрэгжих боломж, зорилгод хүрэх байдал, бусад хууль тогтоомжтой харилцан уялдах уялдааг хангах зорилгоор дараах зөвлөмжийг өгч байна:

- **Орон нутгийн төсөв ба санхүүжилтийн механизмыг бодитой болгох:** Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд орон нутгийн нөөц бүрдүүлэх, хадгалах, сэлгэх зардал нь тухайн орон нутгийн төсвийн чадавхаас хамааран хүндрэл үүсгэх магадлалтай тул төсвийн хуваарилалт, санхүүжилтийн эх үүсвэрийг илүү тодорхой болгох зохицуулалтыг тусгах.
- **Цахим мэдээллийн санд тайлагнах хугацааг боловсронгуй болгох:** Орон нутгийн нөөцийн мэдээллийг өөрчлөлт орсон тухай бүр ажлын 5 өдрийн дотор гамшгийн мэдээллийн санд бүртгүүлэх зохицуулалтыг орон нутгийн анхан шатны нэгжүүдийн цахим болон хүний нөөцийн бодит бололцоотой уядуулан шат дараатай хэрэгжүүлэх эсхүл хугацааны зохих уян хатан нөхцөлийг бүрдүүлэх.
- **Гэрээт хадгалагчийн шалгуур, хяналтыг нарийвчлах:** Гэрээт хадгалагчаар сонгогдох хуулийн этгээдэд тавигдах шаардлага (стандартын агуулах, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ, аюулгүй байдлын шалгалт) нь орон нутгийн түвшинд хэрэгжихэд зарим хязгаарлалт үүсгэж болзошгүй тул сонгон шалгаруулах журам болон чанарын хяналтын механизмыг илүү ойлгомжтойгоор хуульчилж өгөх.
- **Гамшгийн үеийн шуурхай удирдлага ба эрх зүйн уялдааг бэхжүүлэх:** Онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр бараа материалыг шуурхай гаргах зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ гамшгийн голомтод ажиллах бусад байгууллагууд болон Онцгой комиссын шийдвэртэй давхардал үүсгэхгүй байх, хариуцлагын тодорхой хязгаар тогтоох.

---oOo---